



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/194/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас:323266 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас:323266 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn Аудитор: С.Билгүтэй Утас:323266 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	21
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	26

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СУГ	Соёл урлагийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/306  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,311,713.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад харьяа аймаг, орон нутгийн газруудад нийт 264,750.0 мянган төгрөгийг олгож, гүйцэтгэлийг хянадаггүй, зарцуулалтын нотлох баримт, ажлын тайлан, үр дүнг бодитой үнэлдэггүй, дотоод хяналт хэрэгжүүлдэггүй;
- Дээд шатны төсөв захирагчаас эрх шилжүүлэн авсан 1,000,000.0 мянган төгрөгийн ажлыг худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан;
- Хуульд заасан мэргэжлийн ажил үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн 16,000.0 мянган төгрөг, байгууллагын дотоод нөөц боломжийг харгалзан үзэлгүй зөвлөх үйлчилгээ авсан 5,000.0 мянган төгрөг, чанарын баталгааг дутуу суутгасан 1,956.0 мянган төгрөг, өмнөх оны санхүүгийн тайланд өглөгөөр

тусгаагүй, хэвлэл мэдээллийн зардалд зарцуулсан 4,500.0 мянган төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу дүрс бичлэг хийлгүүлэх зардалд 10,000.0 мянган төгрөг, цалин хөлсний нэмэгдэл урамшууллыг үр дүнтэй уялдуулан олгоогүй 9,507.0 мянган төгрөгийн зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” “зохистой буюу нийцсэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд 3,000,000.00 мянган төгрөгийг төсөвлөж, соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд 250 өвийн 800 орчим хөтөлбөрт арга хэмжээг аймаг, нийслэлийн 22 отогт 852 өвлөн уламжлагч, 239 өвлөн суралцагчдыг түшиглэн зохион байгуулсан байна. Арга хэмжээг 260,000 гаруй хүн үзсэн нь өнгөрсөн жилээс 53 хувиар өссөн гэсэн судалгаа гарсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дээд шатны төсөв захирагчаас эрх шилжүүлэн авч Үндэсний их баяр наадам, “Монгол бахархал”, “Соёлын наадам”, “Дээлтэй Монгол наадам” Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль, Мөнгөн мод наадам, Монгол Улсыг “Go Mongolia” уриан дор олон улсад сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан “Монгол” нүүдэлчин өвлийн фестиваль, “Мазаалай” цас мөсний хотхон байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд нийт 6,396,548.7 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. M.* Ц.НАРАНЧИМЭГ



**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>376,281,348.35</b>	<b>266,589,325.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>264,710,000.00</b>	<b>129,012,800.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	264,710,000.00	129,012,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>111,571,348.35</b>	<b>137,576,525.00</b>
35100	Түүхий эд материал	65,707,683.35	104,485,000.00
35110	Тусгай зориулалттай материал	65,707,683.35	104,485,000.00
35400	Хангамжийн материал	45,863,665.00	33,091,525.00
35410	Бичиг хэргийн материал	3,459,300.00	3,560.00
35420	Аж ахуйн материал	29,920,065.00	22,594,065.00
35470	Бусад хангамжийн материал	12,484,300.00	10,493,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>603,929,756.71</b>	<b>627,691,388.86</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>603,929,756.71</b>	<b>627,691,388.86</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>603,929,756.71</b>	<b>613,051,013.85</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	188,014,784.80	197,927,584.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,647,131.90)	(93,342,099.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,014,698.00	146,762,413.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,515,044.16)	(25,775,134.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	354,771,000.00	464,571,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,708,550.03)	(77,092,750.11)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	<b>14,640,375.01</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	-	19,520,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,880,124.99)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>980,211,105.06</b>	<b>894,280,713.86</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>172,770,560.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>172,770,560.00</b>
41300	Өглөг	-	172,770,560.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	34,800,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,869,260.00
41360	Бусад өглөг	-	135,101,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	135,101,300.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>980,211,105.06</b>	<b>721,510,153.86</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>980,211,105.06</b>	<b>721,510,153.86</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	980,211,105.06	721,510,153.86
51210	Өмнөх үеийн үр дүн	363,803,547.52	980,211,105.06
51220	Тайлант үеийн үр дүн	616,407,557.54	(258,700,951.20)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>980,211,105.06</b>	<b>894,280,713.86</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,176,172,880.00</b>	<b>7,979,825,515.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>166,682,180.00</b>	<b>7,979,825,515.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	166,682,180.00	11,550,515.00

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	141,426,980.00	11,550,515.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,255,200.00	-
122	Тусламжийн орлого	-	7,968,275,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,968,275,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,240,660,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,240,660,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,727,615,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,720,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,615,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	10,009,490,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,855,790,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,855,790,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,153,700,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,153,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	700,000.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,559,765,322.46</b>	<b>8,238,526,466.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,559,765,322.46</b>	<b>8,238,526,466.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,218,154,378.15</b>	<b>8,022,450,642.01</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	894,840,453.04	1,325,502,867.81
210101	Үндсэн цалин	560,672,192.85	764,638,792.82
210102	Нэмэгдэл	126,801,844.19	223,122,827.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,006,000.00	252,103,962.47
210104	Урамшуулал	81,360,416.00	85,637,285.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,675,172.31	154,057,700.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	75,561,371.94	106,852,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,854,881.78	12,570,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,545,288.41	6,285,400.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,290,386.27	6,285,400.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	18,423,243.91	22,063,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,533,000.00	82,080,000.00
210304	Байрны түрээс	73,533,000.00	82,080,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,835,600.26	63,624,700.00
210401	Бичиг хэрэг	11,102,571.20	12,700,844.00
210402	Тээвэр, шатахуун	2,291,967.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,741,762.06	8,543,936.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,699,300.00	35,079,920.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	7,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,443,300.00	-

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	8,443,300.00	-
2107	Томилолт, зочны зардал	25,447,279.20	10,000,000.00
210702	Дотоод албан томилолт	25,447,279.20	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,047,806,026.57	1,615,872,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,047,806,026.57	1,615,872,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,573,546.77	4,771,312,574.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,670,354.00	4,646,314,301.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	778,890.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,903,192.77	124,219,382.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>341,610,944.31</b>	<b>216,075,824.19</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	-
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,909,985.00	75,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,300,000.00	75,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,129,985.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,480,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	287,700,959.31	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	260,697,942.19	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	27,003,017.12	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	141,075,824.19
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	141,075,824.19
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>616,407,557.54</b>	<b>(258,700,951.20)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>616,407,557.54</b>	<b>(258,700,951.20)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,088,385,833.00</b>	<b>8,232,985,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>8,232,985,000.00</b>
122	Тусламжийн орлого	-	8,232,985,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	8,232,985,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,240,660,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,240,660,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,992,325,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,984,710,000.00

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,615,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,088,385,833.00</b>	<b>-</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,855,790,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,855,790,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,232,595,133.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,231,895,133.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	700,000.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,811,485,833.00</b>	<b>8,096,375,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,811,485,833.00</b>	<b>8,096,375,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,148,394,888.69</b>	<b>7,880,299,175.81</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	886,755,346.24	1,290,702,867.81
210101	Үндсэн цалин	553,583,251.77	729,838,792.82
210102	Нэмэгдэл	126,857,448.53	223,122,827.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,808,334.28	252,103,962.47
210104	Урамшуулал	80,506,311.66	85,637,285.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,760,279.11	154,057,700.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	75,266,498.30	106,852,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	8,854,881.78	12,570,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,840,165.05	6,285,400.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,290,386.27	6,285,400.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	18,508,347.71	22,063,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,376,000.00	82,080,000.00
210304	Байрны түрээс	80,376,000.00	82,080,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,480,629.06	12,984,700.00
210401	Бичиг хэрэг	2,966,100.00	1,710,704.00
210402	Тээвэр, шатахуун	2,291,967.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,967,062.06	8,543,936.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,055,500.00	2,730,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,582,740.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,438,800.00	-
210602	Тавилга	19,501,020.00	-
210604	Урсгал засвар	19,642,920.00	-
2107	Томилолт, зочны зардал	72,703,569.20	10,000,000.00
210702	Дотоод албан томилолт	72,703,569.20	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,871,204,746.08	1,675,508,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,871,204,746.08	1,675,508,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,531,579.00	4,654,965,708.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,531,579.00	4,654,151,818.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	813,890.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>663,090,944.31</b>	<b>216,075,824.19</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	141,075,824.19
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	141,075,824.19
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	141,075,824.19
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	12,063,024.19

САГ-2026/194/НА-СТА-ТШЗ

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	129,012,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,679,985.00	75,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,300,000.00	75,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,129,985.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,250,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	552,410,959.31	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	260,697,942.19	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	291,713,017.12	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>276,900,000.00</b>	<b>136,610,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>276,900,000.00</b>	<b>136,610,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>276,900,000.00</b>	<b>136,610,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	276,900,000.00	136,610,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	276,900,000.00	136,610,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(276,900,000.00)</b>	<b>(136,610,000.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-</b>	<b>-</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	363,803,547.52	363,803,547.52
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	363,803,547.52	363,803,547.52
9	Тайлант үеийн үр дүн	-	-	616,407,557.54	616,407,557.54
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	980,211,105.06	980,211,105.06
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	980,211,105.06	980,211,105.06
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(258,700,951.20)	(258,700,951.20)
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>721,510,153.86</b>	<b>721,510,153.86</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>6,932,043,600.00</b>	<b>6,228,596,975.81</b>	<b>703,446,624.19</b>	<b>89.9</b>
12	<b>Татварын бус орлого</b>	<b>6,932,043,600.00</b>	<b>6,228,596,975.81</b>	<b>703,446,624.19</b>	<b>89.9</b>
122	Тусламжийн орлого	6,932,043,600.00	6,228,596,975.81	703,446,624.19	89.9
122005	Төсвөөс санхүүжих	6,932,043,600.00	6,228,596,975.81	703,446,624.19	89.9
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,932,043,600.00</b>	<b>6,228,596,975.81</b>	<b>703,446,624.19</b>	<b>89.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,932,043,600.00</b>	<b>6,228,596,975.81</b>	<b>703,446,624.19</b>	<b>89.9</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,857,043,600.00	6,153,596,975.81	703,446,624.19	89.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,290,926,800.00	1,290,702,867.81	223,932.19	100.0
210101	Үндсэн цалин	821,110,800.00	729,838,792.82	91,272,007.18	88.9
210102	Нэмэгдэл	228,167,800.00	223,122,827.38	5,044,972.62	97.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	157,325,900.00	252,103,962.47	(94,778,062.47)	160.2
210104	Урамшуулал	84,322,300.00	85,637,285.14	(1,314,985.14)	101.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,168,400.00	154,057,700.00	3,110,700.00	98.0
210201	Тэтгэврийн даатгал	106,852,400.00	106,852,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	12,570,800.00	12,570,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,285,400.00	6,285,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,285,400.00	6,285,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	25,174,400.00	22,063,700.00	3,110,700.00	87.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,748,000.00	82,080,000.00	7,668,000.00	91.5
210304	Байрны түрээс	89,748,000.00	82,080,000.00	7,668,000.00	91.5
2104	Хангамж, бараа материалын зардал	15,127,800.00	12,984,700.00	2,143,100.00	85.8
210401	Бичиг хэрэг	4,984,100.00	1,710,704.00	3,273,396.00	34.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,985,900.00	8,543,936.00	(558,036.00)	107.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,157,800.00	2,730,060.00	(572,260.00)	126.5
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210702	Дотоод албан томиллолт	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	791,280,000.00	186,176,000.00	605,104,000.00	23.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	791,280,000.00	186,176,000.00	605,104,000.00	23.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,502,792,600.00	4,417,595,708.00	85,196,892.00	98.1

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,501,978,700.00	4,416,781,818.00	85,196,882.00	98.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	813,900.00	813,890.00	10.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,000,000.00	75,000,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,000,000.00	75,000,000.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	75,000,000.00	75,000,000.00	-	100.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	-	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>41.00</b>	<b>38.00</b>	-	<b>92.7</b>
620001	Удирдах ажилтан	1.00	-	-	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	33.00	-	97.1
620003	Үйлчлэх ажилтан	6.00	5.00	-	83.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

		/төгрөгөөр/
Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,992,325,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,992,325,000.00</b>
122	Тусламжийн орлого	1,992,325,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	1,992,325,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,992,325,000.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,984,710,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,615,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,863,312,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,863,312,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,863,312,200.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,583,312,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,583,312,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	280,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	280,000,000.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>129,012,800.00</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(129,012,800.00)</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(129,012,800.00)</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар нь төрөөс соёл урлагийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар соёл урлагийн салбарын нийгэм эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх чиг үүргийг нэмэгдүүлэх үүрэгтэй Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Соёл урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Соёлын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичигт заасан зорилтыг хэрэгжүүлэх удирдлага, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- Соёлын өвийг хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гэмтэх аюул учирсан соёлын өвийг сэргээн засварлах, соёлын өвийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар цогц арга хэмжээ авах;
- Соёл, урлагийн төрөл зүйлийг жигд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чанартай, хүртээмжтэй, соёлын үйлчилгээг иргэдэд хүргэх, сурталчлах;
- Соёлын салбарын салбар дундын уялдаа, түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Соёлын салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Тухайлбал:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол;
- Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”

Соёл урлагийн газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ, салбарын хяналтын хэлтэс нь Соёлын сайдын 2021 оны А/43 тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”, Соёл

урлагийн газрын даргын 2024 оны А/16 тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалтын зохион байгуулах журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Соёл урлагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85,930.4 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	264,710.0	129,012.8	(135,697.2)
Бараа материал	111,571.3	137,576.5	26,005.2
Үндсэн хөрөнгө	603,929.8	627,691.4	23,761.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>980,211.1</b>	<b>894,280.7</b>	<b>(85,930.4)</b>
Өр төлбөр	-	172,770.6	172,770.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	980,211.1	721,510.1	(258,701.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>980,211.1</b>	<b>894,280.7</b>	<b>(85,930.4)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан *авлага, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо* данснууд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 135,697.2 мянган төгрөгөөр буурсан нь наадмын тайз, хувцас, хэрэгсэл хадгалах хашаа барих тендэрт шалгарсан гүйцэтгэгч ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилт 94,866.0 мянган төгрөг, ССАЖЗ-ын сайдын 2024 оны А/57 дугаар “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай”, 2025 оны А/262 дугаар “Утга зохиолын шилдэг бүтээлийг улсын санд худалдах авах жагсаалт батлах тухай”, СУГ-ын даргын 2025 оны А/17 дугаар тушаалд үндэслэн утга зохиолын шилдэг бүтээлийг сонгон шалгаруулах, үнэлж, дүгнэлт гаргах 30,250.0 мянган төгрөг, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийн болон соёлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг цахим сүлжээнд түгээх гэрээт ажлыг төлбөр 10,581.2

мянган төгрөг, нийт 135,697.2 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснийг тайланд онд барагдуулснаас шалтгаалсан.

- Өр төлбөр дансны үлдэгдэл 172,770.6 мянган төгрөг болсон нь тайлант онд ажилтнаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 34,800.0 мянган төгрөг, СЯ-тай тооцоо нийлж баталгаажуулсан 129,012.8 мянган төгрөг, чанарын баталгааг суутган барьж үлдсэн 2,934.0 мянган төгрөг, бичиг хэрэг, хангамжийн материалын зардал 6,023.8 мянган төгрөгийн өр төлбөрийг шинээр тайлагнасан нь нөлөөлсөн.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 721,510.1 мянган төгрөг болж, 258,701.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,848,924.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 551,060.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 410,191.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 55,471.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 111,369.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 67,101.2 мянган төгрөг, нормативт зардал 7,860.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 164,800.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 32,060.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,587,027.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 32,060.0 мянган төгрөг, нийт 2,467,941.1 мянган төгрөгийн зардлыг бууруулж, 6,932,043.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 6,932,043.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар батлагдсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,240,660.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 6,228,597.0 мянган төгрөгийг зарцуулж, 12,063.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,228,597.0 мянган төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,334.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 85,196.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 7,668.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 2,143.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,565,763.6	1,552,617.7	13,145.9	99.1
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	767,280.0	162,176.1	605,103.9	21.1
81908	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	24,000.0	24,000.0	-	100.0

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

81919	Оны шилдэг уран бүтээлч найруулагчийн шагнал	75,000.0	75,000.0	-	100.0
81952	Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль	3,000,000.0	2,917,523.1	82,476.9	97.2
82801	Улсын их баяр наадам	1,500,000.0	1,497,280.1	2,719.9	99.8
<b>Дүн</b>		<b>6,932,043.6</b>	<b>6,228,597.0</b>	<b>703,446.60</b>	<b>89.9</b>

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

**Бүтэц орон тоо:** Соёл урлагийн газрын 2025 оны батлагдсан цалингийн сан 1,290,926.8 төгрөг буюу 45 орон тоотой, гүйцэтгэлээр 1,290,702.9 төгрөг буюу 38 албан хаагчтай ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Соёл урлагийн газрыг 41 орон тоотой байхаар тогтоосон байна. Соёл урлагийн газар нь байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулах арга хэмжээний хүрээнд батлагдсан орон тоог 4-өөр бууруулж 4 газар, 2 хэлтэстэй байхаар бүтэц, зохион байгуулалттай ажиллахаар төлөвлөсөн байна. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/1204 бичгээр чиг үүргийн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах албан бичгийг ирүүлсний дагуу бүтэц зохион байгуулалт, орон тоо, чиг үүргийн мэдээллийг хүргүүлсэн байна.

**Унаа, хоолны хөнгөлөлт:** Соёл урлагийн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/87 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн унаа, хоолны хөнгөлөлтийг 34,000 төгрөгөөр тогтоосон байна. Тус байгууллагын 2025 оны хоол, унааны хөнгөлөлтийн батлагдсан төсөв 157,325.9 мянган төгрөг, гүйцэтгэлээр 252,104.0 мянган төгрөг байгаа нь цалингийн сангаас хоол унааны зардал гаргаж гүйлгэн зарцуулсан байна.

**Албан томилолт:** Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 04/353 тоот дугаартай “Хамтарсан хяналт шалгалт, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх” албан бичиг ирүүлсний дагуу Соёл урлагийн газрын даргын А/07, А/19 тушаалаар 4,330.0 мянган төгрөгийг томилолтын зардлыг олгож, Булган, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймаг, сумдад ажилласан байна. Соёлын сайдын 2025 оны А/3 тушаалаар Швейцарын Холбооны улсын Цюрих хотын Ритберг музейд зохион байгуулагдахаар төлөвлөж буй “Монгол Улс – Цаг хугацааны аялал” үзэсгэлэнгийн бэлтгэл ажлыг хэлэлцэх зорилгоор тийзний зардал болох 5,670.0 мянган төгрөгийг байгууллагын удирдлагад олгосон байна.

**Сургалт, семинар:** Соёл урлагийн газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/32 тушаалаар Соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх арга зүйн сургалтыг зохион байгуулах 3,932.5 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 3,314.4 мянган төгрөг, Хяналт, шинжилгээ, үнэлгээний салбарын сургалтын зардалд тушаал шийдвэргүйгээр 1,213.9 мянган төгрөг, нийт 4,528.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Хэвлэл, мэдээлэл:** Тайлант онд Мөнгөн мод, “Монгол” нүүдэлчин өвлийн фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг сурталчлан таниулах зорилгоор шууд дамжуулалт, сошиал түгээлт хийх, маркетинг, контент сурталчилгаа бэлтгэх, дүрс бичлэг хийлгэх, 33 байгууллага, 8 хувь хүнтэй гэрээ байгуулж, 494,207.8 мянган төгрөгийг олгосон байна.

**Программ хангамжийн бүртгэл:** Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг жил бүр уламжлал болгон зохион байгуулахтай холбогдуулан наадмын танилцуулга, оролцогчдын бүртгэлийг баталгаажуулах, мэдээ мэдээллийг түгээх, хянах самбараар дамжуулан

САГ-2026/194/НА-СТА-ТШЗ

оролцогчдын мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдээлэх зориулалт бүхий веб сайттай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас эрх шилжүүлсэн Монгол Улсыг “Go Mongolia” уриан дор сурталчлан таниулах чиглэлээр хэрэгжүүлсэн "Монгол" нүүдэлчин өвлийн соёлын фестиваль, “Мазаалай” цас, мөсөн хотхон байгуулах байгуулахтай холбоотой 1,670,000.0 мянган төгрөг, Мөнгөн мод наадмыг зохион байгуулах 50,000.0 мянган төгрөг, өмнөх оны авлагаар туссан утга зохиолын шилдэг бүтээл улсын санд бүртгэх, мэдээ мэдээллийн гэрээт үйл ажиллагааны зардал, тайз тоног төхөөрөмжийн агуулахын газарт барих хашааны тендерийн санхүүжилт 264,710.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,615.0 мянган төгрөг, нийт 1,992,325.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 1,863,312.2 мянган төгрөгийг зарцуулж, 129,012.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Соёл урлагийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/24 тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Уг төлөвлөгөөнд музейн үзмэр худалдан авах 150,000.0 мянган төгрөг, соёл, урлагийн арга хэмжээг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд 500,000.0 мянган төгрөг, Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль 3,000,000.0 мянган төгрөг, Үндэсний их баяр наадмын соёл, урлагийн үйл ажиллагаа 1,500,000.0 мянган төгрөг, Мөнгөн мод оны шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах ёслолын үйл ажиллагаанд 200,000.0 мянган төгрөг, нийт 5,350,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгаж, хагас жилээр 6 төсөл арга хэмжээг 1,065,825.0 мянган төгрөгөөр худалдан авахаар өөрчлөлт оруулсан байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг 100 хувьтай тайлагнасан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана ” гэж заасны дагуу Соёл урлагийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Соёл урлагийн газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Соёл урлагийн газрын үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Санхүүгийн аудитын газрын аудитор С.Билгүтэй, ахлах аудитор Б.Лхагвацэнд нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 9,559,765.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 95,597.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа үйлчилгээний бусад зардлыг 85,196.9 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд албан тушаалын автомашинтай холбоотой сэлбэг, шатахууны зардал 15,741.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,438,172.4 мянган төгрөгийн зөрчлөөс 1,438,172.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 29 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Соёл урлагийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/24 тушаалаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, 5,350,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй үр дагавар үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 44.3-т “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ”, 48 дугаар зүйлийн 48.2.1-т “худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хугацааг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Монгол Улсыг “Go Mongolia” уриан дор олон улсад сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан “Монгол” нүүдэлчин өвлийн фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахтай холбоотой 79 байгууллага, 35 хувь хүнтэй хэвлэл, тохижилт, түрээс, тээвэр зэрэг ижил төрлийн ажил үйлчилгээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүйгээр, төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан хувааж, 1,438,172.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

САГ-2026/194/НА-СТА-ТШЗ

**Илрүүлэлт 3:** Тус байгууллагын бүтэц орон тоог 3 газар, 4 хэлтэстэй байхаар баталж, үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тайлант хугацаанд нийт 12 төрийн албан хаагчийг мэргэжилтэн, хэлтэс, газрын даргын албан үүргийг 6 сараас дээш хугацаагаар түр орлон гүйцэтгүүлж байгаа нь хавсран гүйцэтгэж байгаа ажилтны ачаалал нэмэгдэж, ажлын чанар, үр дүн буурах мөн чиг үүргийн давхардал, хариуцлагын тодорхойгүй байдал үүсэж, дотоод хяналтгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т "мэргэшсэн, тогтвортой байх", 27 дугаар зүйлийн 27.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх арга хэмжээг төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлж, батлагдсан орон тоог гүйцээж ажиллах зөвлөмж өгсөн.

**Илрүүлэлт 4:** Соёл урлагийн газрын даргын 2023 оны А/13 "Агентлагийн ажлын байрны нэр, ангилал, зэрэглэл шинэчлэн батлах тухай", А/21 "Газрын орон тоо, албан хаагчдын тушаалын цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар алба хаагчдын цалин, нэмэгдлийг батлан ажиллаж, одоог хүртэл шинэчлээгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ", "Соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Агентлагийн ажлын байрны нэр, албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн шатлалыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Соёл урлагийн газрын завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж авснаар эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 7,265.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулан, 341,085.4 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Акт	1	7,265.0	1	7,265.0	100.0
Зөвлөмж	6	341,085.4	6	341,085.4	100.0
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>348,350.4</b>	<b>4</b>	<b>348,350.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Урлаг, соёлын арга хэмжээнд зориулж худалдан авч буй бараа материалын ашиглалт, зарцуулалтад хэрхэн хяналт тавьж буй асуудал;
- Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагч, шилдэг уран бүтээлч, аймаг, нийслэлийг шагнаж урамшуулахтай холбоотой хууль эрх зүй, шагнал урамшууллын хэмжээг тогтоож буй төсөвлөлт, сонгон шалгаруулалт, зөвлөлийн гишүүд, тэмдэглэл, тайлан, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж буй асуудал.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,120.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

- Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулахтай холбогдуулан 19,520.5 мянган төгрөгийн веб хуудас хийлгэснийг шууд зардлаар тайлагнасан.
- Шилдэг өвлөн уламжлагчдад гардуулах мөргийн бүтээгдэхүүнийг 9,600.0 мянган төгрөгөөр худалдан авч, орлогод аваагүй, шууд зардлаар тайлагнасан.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцээгүй, “үнэн зөв байдал”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,311,713.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 1,956.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,025,340.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 284,416.5 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,311,713.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,216,115.4 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Наадмын тайз, хувцас, хэрэгсэл хадгалах хашаа барих тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй 97,800.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт заасан тусгай шаардлага болон СУГ/2024-335 дугаар гэрээний 4-р дүгээр хавсралтад заасан 5 хувийн чанарын баталгааны барьцаа төлбөрөөс 1,956.0 мянган төгрөгийг дутуу суутгасан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-т "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно", СУГ/2024-335 дугаар гэрээний 4 дүгээр хавсралтын Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 6.7-т "Чанарын баталгаа шаардах эсэх: шаардана", "Чанарын баталгааны хэмжээ: гэрээний үнийн дүнгийн 5%" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Чанарын баталгааны барьцаа төлбөрөөс дутуу суутгасан 1,956.0 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагаас гаргуулж, төсөвт байгууллагын өөрийн дансанд нь төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

5.2.1. Соёл урлагийн газрын даргын тушаалаар батлагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийн ерөнхий төлөвлөлтийн зургийн дагуу кадастрын цэг хатгах ажлыг тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж 16,000.0 мянган төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Кадастрын зураглалыг мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ", Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3-т "Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно", 3.7-т "газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээс мэргэжлийн ажил, үйлчилгээ авдаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2.2. Соёл урлагийн газрын албан хаагчид худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан бөгөөд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулахад хувь хүнээс зөвлөх үйлчилгээ авч 5,000.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Үр ашигтай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т "Худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтан, албан тушаалтан худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй төлөвлөж зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2.3. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/30 дугаар эрх шилжүүлэх тушаалаар аялал жуулчлалын зориулалтын үндсэн үйл ажиллагааны зардалд батлагдсан 1,000,000.0 мянган төгрөгийн төсвийг Соёл урлагийн газрын даргын тушаалаар "Мазаалай" цас мөсөн хотхон байгуулах ажилд зарцуулахдаа 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэгч хуулийн этгээд 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс ажлыг эхлүүлсэн. Мөсөн хотхон байгуулахдаа нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, гэрээ байгуулсан хуулийн этгээдтэй өмнөх онуудад мөсөн хотхоны ажлыг гүйцэтгүүлж байсан бөгөөд 2024 онд хийсэн "Мазаалай мөсөн хотхоны байгууламж"-ийн оюуны өмч, зохиогчийн эрхийн гэрчилгээтэй боловч 2025 онд гүйцэтгэсэн

30 төрлийн мөсөн баримлаас оюуны өмчид хамаарах хэсгийг тодорхойлоогүй, шууд гэрээ байгуулж өрсөлдөөнийг хязгаарласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 13.2.3-т "тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн", 13.2.4-т "бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн", 13.2.7-т "аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн" гэж заасантай тус тус нийцэхгүй.

**Шийдвэрлэсэн:** Мөсөн хотхон байгуулахдаа нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, гэрээ байгуулахаас өмнө ажлыг эхлүүлдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2.4. Соёл урлагийн газрын даргын 2025 оны А/23 тушаалаар 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр Ерөнхий нягтлан бодогчид 2 сар, няравт үндсэн цалингийн 50 хувиар урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Соёл урлагийн газрын даргын 2025 оны А/46 дугаартай тушаалаар "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад харьяа аймаг, орон нутгийн газруудад 264,750.0 мянган төгрөг, архивын дүрс бичлэг хийлгэх 10,000.0 мянган төгрөг, нийт 274,750.0 мянган төгрөгийг олгож, гүйцэтгэлийг хянадаггүй, зарцуулалтын нотлох баримт, ажлын тайлан, үр дүнг бодитой үнэлдэггүй, дотоод хяналт хэрэгжүүлдэггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 31 дүгээр зүйлийн 31.1.2-д "хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн захирагч нь хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн хэрэгжилт, хүрэх үр дүнг үнэлж, гүйцэтгэлийн тайлан баримтын бүрдлийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өгсөн.

## **2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Нэр бүхий аж ахуйн нэгжтэй соёлын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар цахим сүлжээнд түгээх 9,000.0 мянган төгрөгийн гэрээг 2024 онд байгуулж, үлдэгдэл төлбөр болох 4,500.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант онд олгож, гүйцэтгэсэн ажлын тайлан хангалтгүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй.

**Өгсөн зөвлөмж:** Гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажил гүйлгээг бүртгэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулан санхүүгийн тайланд тусгах зөвлөмж өгсөн.

## **3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэлгүйгээр 2 ажилтанд ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тогтоож, 5,166.5 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/166, А/63, А/73 дугаартай тушаалын хавсралт "Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийн 2-т "Ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан байдлыг харгалзан ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй, соёлын ажилтанд шалгуур үзүүлэлтийг баримтлан ур чадварын нэмэгдлийг олгоно", 5-т "Соёлын ажилтны ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг тогтоохдоо шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, цалин хөлсний нэмэгдлийг гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох зөвлөмж өгсөн.

## **4. Хөрөнгө бүртгэхтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулахтай холбогдуулан тайз, жижиг хэрэгслийг хадгалах хашаа бариулсан 1261610944 нэгж талбарын дугаартай 30.0 мянган м.кв газрын эрхийн эзэмших гэрчилгээ нь Соёлын яам дээр гарсан, данс бүртгэлд үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-т "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Газрын эзэмших эрхийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн авч, зохих журмын дагуу үнэлгээг хийж, бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
					Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулахтай холбогдуулан 19,520.5 мянган төгрөгийн веб хуудас хийлгэснийг зардлаар тайлагнасан.	1	19,520.5	1	19,520.5	1	19,520.5				
Шилдэг өвлөн уламжлагчдад гардуулах мөрчийн бүтээгдэхүүнийг 9,600.0 мянган төгрөгөөр худалдан авч, орлогод аваагүй, шууд зардлаар тайлагнасан.	1	9,600.0	1	9,600.0	1	9,600.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>29,120.5</b>	<b>2</b>	<b>29,120.5</b>	<b>2</b>	<b>29,120.5</b>				

### 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Соёл урлагийн газрын даргын 2025 оны А/46 дугаартай тушаалаар "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад харьяа аймаг, орон нутгийн газруудад 264,750.0 мянган төгрөг, архивын дүрс бичлэг хийлгэх 10,000.0 мянган төгрөг, нийт 274,750.0 мянган төгрөгийг олгож, гүйцэтгэлийг хянадаггүй, зарцуулалтын нотлох баримт, ажлын тайлан, үр дүнг бодитой үнэлдэггүй, дотоод хяналт хэрэгжүүлдэггүй байна.	1	274,750.0					1	274,750.0
Нэр бүхий аж ахуйн нэгжтэй соёлын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар цахим сүлжээнд түгээх 9,000.0 мянган төгрөгийн гэрээг 2024 онд байгуулж, үлдэгдэл төлбөр болох 4,500.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант онд олгож, гүйцэтгэсэн ажлын тайлан хангалтгүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	4,500.0					1	4,500.0

Тайлант онд төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэлгүйгээр 2 ажилтанд ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тогтоосон байна.	1	5,166.5					1	5,166.5
Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулахтай холбогдуулан тайз, жижиг хэрэгслийг хадгалах хашаа бариулсан 1261610944 нэгж талбарын дугаартай 30.0 мянган м.кв газрын эрхийн эзэмших гэрчилгээ нь Соёлын яам дээр гарсан, данс бүртгэлд үнэлж бүртгээгүй байна.	1	-					1	-
СУГ-ын даргын тушаалаар батлагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийн ерөнхий төлөвлөлтийн зургийн дагуу кадастрын цэг хатгах ажлыг тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн байна.	1	16,000.0			1	16,000.0		
СУГ-ын албан хаагчид худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан бөгөөд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулахад хувь хүнээс зөвлөх үйлчилгээ авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	5,000.0			1	5,000.0		
ССАЖЗ-ын сайдын 2025 оны А/30 дугаар эрх шилжүүлэх тушаалаар аялал жуулчлалын зориулалтын үндсэн үйл ажиллагааны зардалд батлагдсан 1,000,000,000.0 төгрөгийн төсвийг СУГ-ын даргын тушаалаар "Мазаалай" цас мөсөн хотхон байгуулах ажилд зарцуулахдаа 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэгч хуулийн этгээд 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс ажлыг эхлүүлсэн. Мөсөн хотхон байгуулахдаа нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, гэрээ байгуулсан хуулийн этгээдтэй өмнөх онуудад мөсөн хотхоны ажлыг гүйцэтгүүлж байсан бөгөөд 2024 онд хийсэн "Мазаалай мөсөн хотхоны байгууламж"-ийн оюуны өмч, зохиогчийн эрхийн гэрчилгээтэй боловч 2025 онд гүйцэтгэсэн 30 төрлийн мөсөн баримлаас оюуны өмчид хамаарах хэсгийг тодорхойлоогүй, шууд гэрээ байгуулж өрсөлдөөнийг хязгаарласан.	1	1,000,000.0			1	1,000,000.0		
СУГ-ын даргын 2025 оны А/23 тушаалаар 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр Ерөнхий нягтлан бодогчид 2 сар, няравт үндсэн цалингийн 50 хувиар урамшуулал олгосон байна.	1	4,340.5			1	4,340.5		
Наадмын тайз, хувцас, хэрэгсэл хадгалах хашаа барих тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй 97,800,000.00 төгрөгийн гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт заасан тусгай шаардлага болон СУГ/2024-335 дугаар гэрээний 4-р дүгээр хавсралтад заасан 5 хувийн чанарын баталгааны барьцаа төлбөрийг дутуу суутгасан байна.	1	1,956.0	1	1,956.0				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>1,311,713.0</b>	<b>1</b>	<b>1,956.0</b>	<b>4</b>	<b>1,025,340.5</b>	<b>4</b>	<b>284,416.5</b>

### 6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СУГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/24 тушаалаар “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, 5,350,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй үр дагавар үүсгэсэн.	1	-			1	-		
Монгол Улсыг “Go Mongolia” уриан дор олон улсад сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан "Монгол" нүүдэлчин өвлийн фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахтай холбоотой 79 байгууллага, 35 хувь хүнтэй хэвлэл, тохижилт, түрээс, тээвэр зэрэг ижил төрлийн ажил үйлчилгээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүйгээр, төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан хуваасан.	1	1,438,172.3			1	1,438,172.3		
Тус байгууллагын бүтэц орон тоог 3 газар, 4 хэлтэстэй байхаар баталж, үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тайлант хугацаанд нийт 12 төрийн албан хаагчийг мэргэжилтэн, хэлтэс, газрын даргын албан үүргийг 6 сараас дээш хугацаагаар түр орлон гүйцэтгүүлж байгаа нь хавсран гүйцэтгэж байгаа ажилтны ачаалал нэмэгдэж, ажлын чанар, үр дүн буурах мөн чиг үүргийн давхардал, хариуцлагын тодорхойгүй байдал үүсэж, дотоод хяналтгүй болох эрсдэлтэй байна.	1	-					1	-
Соёл урлагийн газрын даргын 2023 оны А/13 "Агентлагийн ажлын байрны нэр, ангилал, зэрэглэл шинэчлэн батлах тухай", А/21 "Газрын орон тоо, албан хаагчдын тушаалын цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар алба хаагчдын цалин, нэмэгдлийг батлан ажиллаж, одоог хүртэл шинэчлээгүй байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,438,172.3</b>			<b>2</b>	<b>1,438,172.3</b>	<b>2</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 08/A0171328

Улаанбаатар хот

САГ - 2026/194/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Наадмын тайз, хувцас, хэрэгсэл хадгалах хашаа барих ажлын тендерт шалгарсан Онон Бридж ХХК-тай 97,800,000.00 (ерэн долоон сая найман зуун мянга) төгрөгийн гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт заасан тусгай шаардлага болон СУГ/2024-335 дугаар гэрээний 4-р дүгээр хавсралтад заасан 5 хувийн чанарын баталгааны барьцаа төлбөрөөс 1,956,000.00 (нэг сая есөн зуун тавин зургаан мянга) төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-т "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно", СУГ/2024-335 дугаар гэрээний 4 дүгээр хавсралтын Гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 6.7-т "Чанарын баталгаа шаардах эсэх: шаардана", "Чанарын баталгааны хэмжээ: гэрээний үнийн дүнгийн 5%" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Чанарын баталгааны барьцаа төлбөрөөс дутуу суутгасан 1,956,000.00 (нэг сая есөн зуун тавин зургаан мянга) төгрөгийг Онон Бридж ХХК-аас гаргуулж, Соёл урлагийн газрын Төрийн сан дахь 100900034010 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 53/A0171328

Улаанбаатар хот

САГ-2026/194/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газрын даргын тушаалаар 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр ерөнхий нягтлан бодогч, нярвуудад 4,340,500.00 (дөрвөн сая гурван зуун дөчин мянга таван зуу) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), санхүүгийн хэлтсийн дарга (Р.Дулмаа), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Д.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9005107  
ATA15867  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-4.Docx

1526180151



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 54/А0171328

Улаанбаатар хот

САГ - 2026/194/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүтэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсыг "Go Mongolia" уриан дор олон улсад сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан "Монгол" нүүдэлчин өвлийн фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахтай холбоотой 79 байгууллага, 35 хувь хүнтэй хэвлэл, тохижилт түрээс, тээвэр зэрэг ижил төрлийн ажил үйлчилгээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүйгээр, төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан хувааж, 1,438,172,390.00 (нэг тэрбум дөрвөн зуун гучин найман сая нэг зуун далан хоёр мянга гурван зуун ер) төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), санхүүгийн хэлтсийн дарга (Р.Дулмаа), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-4.Docx

9006109  
ATA16057  
9025081411

1526180149



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 55/A0171328

Улаанбаатар хот

САГ-2026/194/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газрын даргын тушаалаар батлагдсан 16,000,000.00 (арван зургаан сая) төгрөгийн төсвийг ерөнхий төлөвлөлтийн зургийн дагуу кадастрын цэг хатгах ажлыг тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Кадастрын зураглалыг мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ", Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3-т "Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно", 3.7-т "газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээс мэргэжлийн ажил, үйлчилгээ авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), санхүүгийн хэлтсийн дарга (Р.Дулмаа), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 56/A0171328

Улаанбаатар хот

САГ - 2026/194/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газрын албан хаагчид худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан бөгөөд худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулахад хувь хүнээс зөвлөх үйлчилгээ авч 5,000,000.00 (таван сая) төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Үр ашигтай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т "Худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажилтан, албан тушаалтан худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамрагдсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй төлөвлөж зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), санхүүгийн хэлтсийн дарга (Р.Дулмаа), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 57/А0171328

Улаанбаатар хот

САГ - 2026/194/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/30 дугаар эрх шилжүүлэх тушаалаар аялал жуулчлалын зориулалтын үндсэн үйл ажиллагааны зардалд батлагдсан 1,000,000,000.00 (нэг тэрбум) төгрөгийн төсвийг Соёл урлагийн газрын даргын тушаалаар "Мазаалай" цас мөсөн хотхон байгуулах ажилд зарцуулахдаа 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэгч хуулийн этгээд 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс ажлыг эхлүүлсэн. Мөсөн хотхон байгуулахдаа нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, гэрээ байгуулсан хуулийн этгээдтэй өмнөх онуудад мөсөн хотхоны ажлыг гүйцэтгүүлж байсан бөгөөд 2024 онд хийсэн "Мазаалай мөсөн хотхоны байгууламж"-ийн оюуны өмч, зохиогчийн эрхийн гэрчилгээтэй боловч 2025 онд гүйцэтгэсэн 30 төрлийн мөсөн баримлаас оюуны өмчид хамарах хэсгийг тодорхойлоогүй, шууд гэрээ байгуулж өрсөлдөөнийг хязгаарласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 13.2.3-т "тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн", 13.2.4-т "бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн", 13.2.7-т "аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мөсөн хотхон байгуулахдаа нээлттэй тендер сонгон шалгаруулалт зарлаагүй, гэрээ байгуулахаас өмнө ажлыг эхлүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), Санхүүгийн хэлтсийн дарга (Р.Дулмаа), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 58/А017/1328

Улаанбаатар хот

САГ - 2026/194/НА - СТА - ТИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газрын даргын А/24 тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталж, 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь хуулийн хугацааг мөрдөж ажиллах, нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглах боломжгүй үр дагавар үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", 48 дугаар зүйлийн 48.2.1-т "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хугацааг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), Санхүүгийн хэлтсийн дарга (Р.Дулмаа), нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ЛХАГВАЦЭНД  
С.БИЛГҮТЭЙ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-4.Docx

1526180147